



ЦАХИМ ЗАСАГЛАЛААР ДАМЖУУЛАН ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦАД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Цахим засаглалын платформ /вэб-аппликейшн/-ыг ашиглан хууль боловсруулах үйл явц дахь иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, түүнчлэн хууль тогтоох үйл явцад өргөдлийн механизмыг ашиглан оролцох чадавхийг нэмэгдүүлэх юм.

ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ /үргэжлэл 2 дахь нүүрэнд/

1. Хамтрагч байгууллагуудтай анхны уулзалтыг зохион байгуулаа.

2015 оны 06 сарын 05-нд төслийг хамтран хэрэгжүүлэх байгууллагын төлөөлөлтэй уулзаж төслийн зорилго, үйл ажиллагааг танилцуулах анхны хамтарсан уулзалтыг зохион байгуулаа.

Уулзалтанд УИХ-ын Өргөдлийн байнгын хороо, Мэдээллийн технологи, шуудан, харилцааны холбооны газар, Ил тод байдлыг дэмжих түншлэлийн төлөөлөл болон Мэдээллийн технологийн зөвлөх ороцсон.

2. Төслийн ажлын хэсэг байгуулагдлаа.

Төслийн ажлын хэсэг нь төслийн хэрэгжилтийг жигд хангах, чиглүүлэх, хяналт тавих, төслийн багт заавар зөвлөгөө өгөх, туслалцаа дэмжлэг үзүүлэх болон төслийн хамтрагч байгууллага хоорондын ажлын уялдааг хангах чиглэлээр ажиллах зорилготой.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн арвантаван гишүүнтэй. Үүнд хууль тогтоох байгууллага болон Засгийн Газрын байгууллага, орон нутгийн Иргэний танхим,

иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллага болон төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөлөөс бүрдэж байна.

Ажлын хэсгийн ажлын чиглэл нь төсөл хэрэгжих хугацаанд цахим засаглалын платформын /вэб-аппликейшн/ бүтэц, загварыг төлөвлөхөд зөвлөгөө өгөх, платформын ашиглалт хэрэглээг өргөжүүлэх, төслийн зорилго болон үйл ажиллагааг хамрагч талуудын ажлын чиглэлтэй уялдуулах, төслийн үр нөлөөг дээшлүүлэх, тогтвортой байдлыг хангахад чиглэгднэ. Өөрөөр хэлбэл төслийн хамтын ажиллагааны гэрээг хэрэгжүүлэх нэгж нь төслийн ажлын хэсэг байх юм.

Түүнчлэн төслийн багаас суурь судалгаа хийх, хамтын ажиллагааны гэрээний төслийг боловсруулах, цахим засаглалын платформын бүтэц загварыг тодорхойлох хөгжүүлэх ажлын хүрээнд 05 болон 06 дугаар сард хамтрагч талуудын төлөөлөлтэй тогтмол уулзалт хийж төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллээр хангах, хамтын ажиллагааг албан ёсоор эхлэх шатанд зөвшилцөх, санал зөвлөмжөө харилцан солилцох чиглэлээр ажиллаж байна.

ХАМТРАГЧИД

- Улсын Их Хурлын Тамгын Газар
- Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороо
- Хууль зүйн яам
- Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
- Нийслэлийн Иргэний танхим
- Хан-Уул дүүргийн Иргэний танхим
- «Ил тод байдлыг дэмжих түншлэл» ТББ-ын сүлжээ
- Хэвлэлийн хүрээлэн
- Сонгогчдын боловсрол төв

САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Нэгдсэн Үндэстний
Байгууллагын Ардчилал Сан

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

Нийгмийн Дэвшил Эмэгтэйчүүд
Хөдөлгөөн ТББ

ХУГАЦАА

Эхлэх: 2015 оны 03 сар
Дуусах: 2017 оны 04 сар

ХАЯГ:

Ардчиллын Ордон, өрөө №208 тоот
Эрхүүгийн гудамж, 7-р хороо, СБД
Улаанбаатар хот, Монгол Улс

Утас: 976 70-135147

Факс: 976 7013-5146

И-Мэйл: womenforsocialpro-
gress@gmail.com

Шууданг хаяг: Улаанбаатар-14192,
Ш/Х-380



ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ /үргэжлэл/

3. Суурь судалгааг төсөл хэрэгжих орон нутгуудад зохион байгуулаа.

Суурь судалгаа нь төслийн үндсэн бүтээгдэхүүн болох цахим засаглалын платформын ашиглалт болон хэрэглээг тодорхойлох, платформыг хэрэглэгчдийн хүлээлт, хандлагад нийцүүлэх, төслийн хэрэгжилтийг бүхэлд нь болон явц дунд нь үнэлэх, сайжруулах, төслийн үр нөлөө, ач холбогдлыг дээшлүүлэх зорилготой.

Судалгаа нь дараах бүтэцтэй хийгдэж байна:

- 1/ Хууль тогтоох байгууллагах, Засгийн газар, орон нутгийн удирдах байгууллагын мэдээллийн ил тод байдал болон иргэдийн оролцооны зохицуулалтыг үнэлэх,
- 2/ Иргэний нийгмийн байгууллагын чадавхийг үнэлэх,
- 3/ Олон нийтийн ойлголт хандлага тогтоох судалгаа ,
- 4/ Одоо хэрэглэгдэж буй иргэдийн оролцоог хангахад чиглэгдсэн цахим хуудас болон аппликейшн-уудын техникийн чадавхийг үнэлэх,
- 5/ Баримт бичгийн судалгаа зэрэг болно.

Суурь судалгааг Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өмнөговь, Хөвсгөл аймгуудад хийлээ. Одоогоор судалгааны мэдээллийг цуглуулж дуусаад байна. Мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, тайлан бэлтгэх ажилд хийгдэж байна.

Судалгааны тайланг төслийн ажлын хэсэгт танилцуулж гишүүдийн санал, зөвлөмжийг тусгах юм.

4. Хамтран ажиллах гэрээ байгуулахаар талуудтай зөвшилцөх ажил хийгдэж байна.

Талуудын хамтын ажиллагааны чиглэлийг тоймлон дурдвал:

- 1/ Цахим засаглалын платформ /вэб-аппликейшн/-ыг ашиглан хууль боловсруулах үйл явц дахь иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх;
- 2/ Хууль тогтоох үйл явцад өргөдлийн механизмыг ашиглан иргэд болон иргэний нийгмийн байгууллагууд оролцох чадавхийг нэмэгдүүлэх;
- 3/ Монгол улсад цахим засаглалыг хөгжүүлэхэд чиглэгдсэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Засгийн Газраас баталсан хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулах, дэмжлэг үзүүлэх;
- 4/ Хууль тогтоох байгууллага болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, зөвшилцөж хамтран ажиллах хоёр талын оролцоонд суурилсан эргэх холбоог өргөжүүлэх замаар ардчиллыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Төслийн багаас хамтын ажиллагааны гэрээний төслийг боловсруулж, талуудын саналыг авахаар бэлтгэж байна.

Хамтын ажиллагааны гэрээний оролцогч талууд нь УИХ-ын Тамгын Газар, УИХ-ын Өргөдлийн байнгын хороо, Мэдээллийн технологи, шуудан, харилцааны холбооны газар, Ил тод байдлыг дэмжих түншлэл юм.

ЗОРИЛТОТ ОРОН НУТАГ

